



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 09/08

Хөхбүрд

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Япон Улсын Хүүхдийн ивээх сангийн 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн SCJ-69/23 албан захидал, сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ны албан бичгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Япон Улсын Хүүхдийн ивээх сангийн гамшигийн эрсдлийн сангийн санхүүжилтэнд хамрагдах малчин өрхийн сонголтыг оновчтой зөв хийх, тусламжийн тараалтыг зөв зохион байгуулах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч: Г.Ганцоож (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Б.Пүрэвсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөл)

Б.Долгорсүрэн (Халамжийн мэргэжилтэн)

Д.Ганбаатар (Уранхайрхан 2 дугаар багийн малчин)

Ё.Дамдинпүрэв (Мэргэн 4 дүгээр багийн малчин)

2. Зөвлөл нь тусламжинд хамрагдах малчин өрхийг “сангийн гамшигийн эрсдэлийн сангийн санхүүжилт бүхий 2022-2023 оны өвөлжилт хүндэрсэн аймгуудын зорилтот бүлгийн малчин өрхөд тусламж үзүүлэх ажлын тусламж үзүүлэх” ажлын удирдамжийн дагуу багийн Засаг дарга нараас гаргуулан авч мэдээллийг маягтаар нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх, тусламжийн тараалтыг зохион байгуулан ажлын тайлангаа дараагийн хурлын хуралдаанд танилцуулахыг зөвлөлийн ахлагч Г.Ганцоож-д үүрэг болгосугай

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА



Б.ОТГОНБАЯР

648801049